ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2024/07/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2024 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Аудитор: М.Ухаанбилэг<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл...........................................4-8

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........................................................................9

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.................................................................9

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.................................................................9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................................9

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт..........9

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв...................................................10

4. Аудитын тайлан.................................................................................................11

4.1 Ерөнхий зүйл ......................................................................................................11

4.2 Материаллаг байдал ...........................................................................................11

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.......................................................11

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...........11

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ......................................12

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ................................................................12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| НА | Нийцлийн аудит |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СС | Сангийн сайдын |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.20 № 148

танай ____________-ны №____________-т

ДОРНОД АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.БАЗАРРАГЧАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайланд материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, үйл явдал гараагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилго, 7 зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн тайланг Хөдөлмөр, халамжийн ерөнхий газраас 93.6 хувиар дүгнэсэн байна.

011020993

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **49,260,952.98** | **57,272,712.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 7,594,412.98 | 36,023,742.98 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 7,594,412.98 | 36,023,742.98 |
| **3121** | **Төгрөг** | 7,594,412.98 | 36,023,742.98 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 7,594,412.98 | 36,023,742.98 |
| **33** | **АВЛАГА** | - | 663,250.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 663,250.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 41,666,540.00 | 20,585,720.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 5,997,887.00 | 521,647.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,997,887.00 | 521,647.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 35,668,653.00 | 20,064,073.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,744,093.00 | 18,604,213.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,924,560.00 | 1,459,860.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,224,604,442.44** | **6,125,280,729.22** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,224,604,442.44 | 6,125,280,729.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,049,487,775.86 | 4,963,469,062.68 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,127,307,566.00 | 5,197,307,566.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (403,760,355.87) | (519,134,951.31) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 300,219,414.24 | 331,046,285.10 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (205,118,195.73) | (230,087,905.25) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 171,102,350.01 | 192,515,490.01 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (87,365,086.21) | (109,227,503.21) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 251,273,057.00 | 251,273,057.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (104,170,973.58) | (150,222,975.66) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,175,116,666.58 | 1,161,811,666.54 |
| 39301 | Програм хангамж | 9,776,900.00 | 9,776,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,385,233.42) | (8,340,233.46) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,171,725,000.00 | 1,160,375,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,273,865,395.42** | **6,182,553,442.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **663,250.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 663,250.00 |
| **413** | **Өглөг** | - | 663,250.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 663,250.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 663,250.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,273,865,395.42** | **6,181,890,192.20** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,273,865,395.42 | 6,181,890,192.20 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,609,677,423.28 | 1,609,677,423.28 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,609,677,423.28 | 1,609,677,423.28 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,497,638,385.18 | 4,405,663,181.96 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,723,875,515.70 | 4,497,638,385.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (226,237,130.52) | (91,975,203.22) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 166,549,586.96 | 166,549,586.96 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,273,865,395.42** | **6,182,553,442.20** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,342,783,036.74** | **2,065,167,462.59** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | - | - |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **114,904,888.74** | **277,920,801.59** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 114,904,888.74 | 277,920,801.59 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 104,900,376.96 | 124,296,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 101,788,000.00 | 124,296,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,112,376.96 | - |
| 120009 | Бусад орлого | 10,004,511.78 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үдсэн хөрөнгө | | 153,624,801.59 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,227,878,148.00** | **1,787,246,661.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,079,207,548.00 | 1,570,181,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,079,207,548.00 | 1,570,181,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 148,670,600.00 | 217,064,761.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,822,200.00 | 100,452,560.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,000,000.00 | 70,966,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 39,848,400.00 | 45,645,901.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,552,023,374.23** | **2,078,923,845.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,552,023,374.23** | **2,078,923,845.81** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,462,163,661.04 | 2,033,799,291.39 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 770,021,649.00 | 1,242,155,700.98 |
| 210101 | Үндсэн цалин | 579,660,569.85 | 720,149,887.98 |
| 210102 | Нэмэгдэл | 164,052,207.15 | 327,111,556.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,928,676.00 | 99,010,019.12 |
| 210104 | Урамшуулал | 5,380,196.00 | 95,884,237.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,318,107.00 | 155,037,055.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,232,807.00 | 106,437,462.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,037,620.80 | 12,568,893.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,500,679.20 | 9,309,699.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,504,300.00 | 2,589,654.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,042,700.00 | 24,131,345.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 64,661,125.06 | 70,355,297.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,190,895.28 | 23,503,202.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,898,213.78 | 31,720,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,572,016.00 | 15,132,095.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,123,816.75 | 55,032,039.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,674,004.00 | 9,981,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,219,638.00 | 23,034,468.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,816,689.75 | 3,597,260.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 451,050.00 | 170,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,962,435.00 | 18,249,111.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 106,706,224.00 | 106,396,316.71 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,592,100.00 | 382,690.00 |
| 210502 | Хоол, хүнс | 100,222,524.00 | 101,530,626.71 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,891,600.00 | 4,483,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,195,925.00 | 5,766,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,711,000.00 | 2,969,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,484,925.00 | 2,796,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 896,000.00 | 7,792,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 896,000.00 | 7,792,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 101,815,528.00 | 137,447,973.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 97,072,128.00 | 129,282,473.29 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 504,300.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 294,200.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,464,500.00 | 5,090,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,087,400.00 | 2,470,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 267,425,286.23 | 253,816,808.61 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,838,526.00 | 49,481,293.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,884,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 224,586,760.23 | 202,451,514.81 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 89,859,713.19 | 45,124,554.42 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 89,494,958.00 | 44,302,020.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,828,210.00 | 20,466,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 61,993,100.00 | 21,136,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,673,648.00 | 2,699,620.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 364,755.19 | 822,534.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 364,755.19 | 809,358.22 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 13,176.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(209,240,337.49)** | **(13,756,383.22)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 10,625,000.03 | 78,218,820.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,625,000.03 | - |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 78,218,820.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (10,625,000.03) | (78,218,820.00) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(219,865,337.52)** | **(91,975,203.22)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,339,670,659.78** | **1,911,542,661.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **111,792,511.78** | **124,296,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 111,792,511.78 | 124,296,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 101,788,000.00 | 124,296,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 101,788,000.00 | 124,296,000.00 |
| 120009 | Бусад орлого | 10,004,511.78 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,227,878,148.00** | **1,787,246,661.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,079,207,548.00 | 1,570,181,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,079,207,548.00 | 1,570,181,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 148,670,600.00 | 217,064,761.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,822,200.00 | 100,452,560.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,000,000.00 | 70,966,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 39,848,400.00 | 45,645,901.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,337,654,907.00** | **1,877,960,331.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,337,654,907.00** | **1,877,960,331.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,241,423,400.81** | **1,832,172,526.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 770,021,649.00 | 1,238,615,700.98 |
| 210101 | Үндсэн цалин | 579,660,569.85 | 716,609,887.98 |
| 210102 | Нэмэгдэл | 164,052,207.15 | 327,111,556.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,928,676.00 | 99,010,019.12 |
| 210104 | Урамшуулал | 5,380,196.00 | 95,884,237.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 97,318,107.00 | 155,037,055.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,232,807.00 | 106,437,462.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,037,620.80 | 12,568,893.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,500,679.20 | 9,309,699.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,504,300.00 | 2,589,654.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,042,700.00 | 24,131,345.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 64,661,125.06 | 70,355,297.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,190,895.28 | 23,503,202.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,898,213.78 | 31,720,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,572,016.00 | 15,132,095.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,158,674.75 | 53,707,080.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,674,004.00 | 9,259,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,197,638.00 | 23,034,468.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,816,689.75 | 3,597,260.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 451,050.00 | 170,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,019,293.00 | 17,646,352.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 106,620,161.00 | 104,348,715.71 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,592,100.00 | 382,690.00 |
| 210502 | Хоол, хүнс | 100,136,461.00 | 99,483,025.71 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,891,600.00 | 4,483,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,550,000.00 | 6,808,660.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,000,000.00 | 3,344,960.00 |
| 210602 | Тавилга | 650,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 7,900,000.00 | 3,463,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 896,000.00 | 7,792,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 896,000.00 | 7,792,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 101,815,528.00 | 138,784,723.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 97,072,128.00 | 130,619,223.29 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 504,300.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 294,200.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,464,500.00 | 5,090,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,087,400.00 | 2,470,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,382,156.00 | 56,723,293.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,382,156.00 | 54,839,293.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,884,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **96,231,506.19** | **45,787,804.42** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 89,494,958.00 | 44,302,020.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,828,210.00 | 20,466,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 61,993,100.00 | 21,136,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,673,648.00 | 2,699,620.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6,736,548.19 | 1,485,784.42 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 364,755.19 | 809,358.22 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгэ | 6,371,793.00 | 676,426.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,015,752.78** | **33,582,330.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **5,153,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **5,153,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 5,153,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 5,153,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(5,153,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,015,752.78 | 28,429,330.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5,578,660.20 | 7,594,412.98 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 7,594,412.98 | 36,023,742.98 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,609,677,423.28 | 166,549,586.96 | 4,497,638,385.18 | 0.00 | 6,273,865,395.42 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,609,677,423.28** | **166,549,586.96** | **4,497,638,385.18** | **0.00** | **6,273,865,395.42** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,609,677,423.28** | **166,549,586.96** | **4,497,638,385.18** | **0.00** | **6,273,865,395.42** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,609,677,423.28** | **166,549,586.96** | **4,497,638,385.18** | **0.00** | **6,273,865,395.42** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,609,677,423.28** | **166,549,586.96** | **4,497,638,385.18** | **0.00** | **6,273,865,395.42** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -91,975,203.22 | 0.00 | -91,975,203.22 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,609,677,423.28** | **166,549,586.96** | **4,405,663,181.96** | **0.00** | **6,181,890,192.20** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,677,346,300.00 | 1,658,477,900.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,677,346,300.00 | 1,658,477,900.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,653,509,600.00 | 1,633,832,521.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,214,588,600.00 | 1,214,173,590.98 |
| 210101 | Үндсэн цалин | 724,605,700.00 | 692,167,777.98 |
| 210102 | Нэмэгдэл | 422,745,600.00 | 327,111,556.27 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,929,300.00 | 99,010,019.12 |
| 210104 | Урамшуулал | 41,308,000.00 | 95,884,237.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 151,823,700.00 | 151,823,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,240,000.00 | 103,224,107.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,145,900.00 | 12,568,893.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,716,800.00 | 9,309,699.30 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,429,200.00 | 2,589,654.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,291,800.00 | 24,131,345.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 70,355,300.00 | 70,355,297.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 22,781,500.00 | 23,503,202.00 |
| 210302 | Түлш, халаалт | 31,720,000.00 | 31,720,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,853,800.00 | 15,132,095.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27,307,800.00 | 25,566,290.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,589,900.00 | 3,542,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,830,300.00 | 2,797,178.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,644,800.00 | 2,695,260.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,050,000.00 | 170,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,192,800.00 | 16,361,352.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 117,047,100.00 | 104,353,015.71 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,586,000.00 | 386,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 110,653,100.00 | 99,483,025.71 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,808,000.00 | 4,483,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,980,200.00 | 2,932,760.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 480,200.00 | 375,360.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 2,557,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 67,406,900.00 | 64,627,867.29 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 63,673,300.00 | 61,162,367.29 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 604,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 144,200.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 41,200.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 472,700.00 | 390,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,470,700.00 | 2,470,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,836,700.00 | 24,645,378.22 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,836,700.00 | 24,645,378.22 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 809,358.22 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,136,400.00 | 21,136,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,700,300.00 | 2,699,620.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,674,346,300.00 | 1,658,477,900.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,570,181,900.00 | 1,570,181,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,570,181,900.00 | 1,570,181,900.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 104,164,400.00 | 88,296,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 104,164,400.00 | 88,296,000.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 67.00 | 67.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 44.00 | 44.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 22.00 | 22.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **67.00** | **67.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 45.00 | 45.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 22.00 | 22.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **218,299,761.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **218,299,761.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 197,833,761.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 27,982,110.00 |
| 210101 | Үндсэн цалин | 27,982,110.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,213,355.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,213,355.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,155,790.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,716,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,237,290.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 902,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,469,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,469,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,792,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,792,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 74,156,856.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 69,456,856.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,700,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 49,152,623.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,268,623.80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,884,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 20,466,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 20,466,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,466,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,911,426.20** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 1,235,000.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 676,426.20 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 218,299,761.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 218,299,761.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 100,452,560.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,966,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,880,901.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,558.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн явцад дахин хянаж шинэчлэн тогтоож 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 2,080.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 20.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоох нь зохиомжтой гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.”, “14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн тохиолдолд албан шаардлага хүргүүлсэн.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлсэн эсэхийг тулган шалгасан. Цахим хуудсанд мэдээллийг байршуулж ажилласан байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 22.5 сая төгрөгийн залруулга хийлгэж, 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, шилэн дансны хугацаа хоцролтод зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж 100 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Төлбөрийн акт | 1 | 456.0 | 1 | 456.0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **456.0** | **2** | **456.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 169,950.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 169,950.0 мянган төгрөгийн алдааг залруулж ажиллалаа.

*Залруулсан алдаа:*

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сургалт дадлагын төвийн байшин, конторын барилгын газар тайланд бүртгэгдээгүй нь УСНББОУС 17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Ахмадын чөлөөт цагийн төвийн барилгыг аймгийн ИТХ-ын 2020 оны 41 дүгээр тогтоолоор шилжүүлсэн барилгын газрыг нь шилжүүлээгүй байна. Энэ нь УСНББОУС 17, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 5,153.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 5,153.0 мянган төгрөгийн нэг албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Халаалтын тень, хивсэнцэр, индукцин плитк зэрэг 5,153.0 мянган төгрөгийн худалдан авалт хийхдээ цахим дэлгүүрээс худалдаж аваагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.”, “14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | То о | Дүн | То о | Дүн | То о | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | То о | Ду н |
| Үндсэн хөрөнгөнд газар, байшин бүртгээгүй | 1 | 114,300.00 | 1 | 114,300.00 | 0 | 0 | 1 | 114,300.00 | 0 | 0 | 0 | 0 |
| Ахмадын чөлөөт цагийн төвийн газар Эрүүл мэндийн төвд давхар бүртгэлтэй байна. | 1 | 55,650.00 | | | 1 | 55,650.00 | 1 | 55,650.00 | | | | |
| Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн | 1 | 22,568.82 | 0 | 0 | 1 | 22,568.82 | 1 | 22,568.82 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 2 | 192,518.82 | 1 | 114,300.00 | 2 | 78,218.82 | 3 | 192,518.82 | 0 | 0.00 | 0 | 0.00 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цахим дэлгүүрээс | 1 | 5,153.0 | 0 | 0 | 1 | 5,153.0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| худалдан авалт хийгээгүй. | | | | | | | | | | | | |
| Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон | 1 | 456.0 | 1 | 456.0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 2 | 5,609.0 | 1 | 456.0 | 1 | 5,153.0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын шилэн дансны мэдээллийн самбарт мэдээллийг шинэчлээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | 1 | 0 | - | - | - | - | 1 | 0 |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 10 сарын 18 өдөр    Дугаар 72 ДОА-2024/07/НА-СТА-ТН43 А1170309    Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал"-ын 3.12-т заасны дагуу Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны Б/77 дугаар тушаалаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 25 хувиар тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 07 дугаар зөвлөмжийн 8 дахь хэсэгт "... Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг төрийн байгууллага зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн албан хаасан хугацааны нэмэгдэлд олгосон 456,000 /Дөрвөн зуун тавин зургаан мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АУДИТОР М.УХААНБИЛЭГ

011050172

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 20 өдөр    Дугаар 09 ДОА-2024/07/НА-СТА-1113 А117089    Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь цахим дэлгүүрээс халаалтын тень, индукцин плитк, хивсэнцэр зэргийг худалдан аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн “14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д заасны дагуу хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.”, “14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.” гэсэн заалтуудтай нийцэхгүй мөн санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Базаррагчаа, нягтлан бодогч Х.Сарандагина нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР М.УХААНБИЛЭГ

011040956